



МОНГОЛ УЛС
ХЭНГИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 06 сарын 18 өдөр

Дугаар А/293

Чингис хот

Нөөцийн махны урамшуулалд
хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Хүнсний тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.5, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2019 оны 08 дугаартай “Аймгийн 2020 оны төсөв батлах тухай” тогтоол, аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.3.1, аймгийн Эдийн засаг, нийгмийг 2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн 10.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хаврын улиралд үүсч болзошгүй махны хомсдол, үнийн өсөлтөөс урьдчилан сэргийлэх зорилгоор нөөцийн махыг борлуулах үйл ажиллагааг хэрэгжүүлэх, урамшуулал олгох ТА-2020/01 дугаартай гэрээний хэрэгжилт хангагдсан тул 50 000 000 /тавин сая/ төгрөгийг “Ханбүргэд Номин” ХХК-д олгосугай.

2. Зарцуулах хөрөнгийн зардлын тооцоог хавсралтаар баталсугай.

3. Дээрх хөрөнгийг 2020 оны аймгийн төсөвт тусгагдсаны дагуу Засаг дарга дансны төвлөрсөн арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /С.Нямдаваа/-д, захирамжийн гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга /Ж.Ганбаатар/-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Н.ГАНБЯМБА

Аймгийн Засаг даргын 2020 оны
06 дугаар сарын 18 өдрийн 4/293
дугаар захирамжийн хавсралт

Нөөцийн махны урамшуулалд зарцуулах хөрөнгийн тооцоо

Д/д	Нэр төрөл	Тоо хэмжээ /тн/	Нэгж урамшууллын үнэ /₮/	Нийт урамшууллын үнэ /₮/
1	Хонины мах	15	1500	22 500 000
2	Ямааны мах	18,33	1500	27 500 000
	Нийт			50 000 000